

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР****АКТ**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.05.05 № 01/24 Ч.А.Т-СА.Т/2014/01/С.Т.А-Т.И.С

Орлого төвлөрүүлэх тухай

Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Сангийн сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тус сангаас олгосон хүүгийн урамшууллын зарцуулагдаагүй үлдэгдэл нийт 478,831,863.37 төгрөг, үүнээс Төрийн банкинд 49,242,163.00 төгрөг, Капитрон банкинд 424,721,933.67 төгрөг, Хас банкинд 4,867,766.70 төгрөг байршиж байгааг авлагаар бүртгэж тайлагнасан,
- Төрийн банк нэр бүхий 6 зээлдэгчийн зээлийн хүүгийн нийт 5,497,117.00 төгрөгийг тус сангаас олгосон хүүгийн урамшууллын эх үүсвэрийн хэмжээнээс хэтрүүлэн хасагдуулга хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1-д “төлбөл зохих төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн болон төвлөрүүлээгүй” зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тавина” гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хүүгийн урамшууллын зарцуулагдаагүй үлдэгдлийн 478,831,863.37 төгрөг, хүүгийн урамшууллын эх үүсвэрийн хэмжээнээс хэтрүүлэн хасагдуулга хийсэн зээлийн хүүгийн 5,497,117.00 төгрөг, нийт 484,328,980.37 төгрөгийг Төрийн сан дах Хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн 900011401 дугаар дансанд татан төвлөрүүлэх.
2. Дээрх хөрөнгийг төвлөрүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга Б.Нямаа, Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Ариунсанаа нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

Үндэсний аудитын газрын
Ахлах аудитор Г.Юра



ЗӨВШӨӨРСӨН:

Санхүүгийн бодлого, өрийн
удирдлагын газрын дарга

Б.Нямаа

Сангийн яамны Төрийн сангийн
газрын дарга Ч.Тавинжил

Санхүүжилт, тайлан бүртгэлийн
хэлтсийн дарга

Ц.Ариунсанаа

